



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1. дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүр улсын төсөвт тусгаж, гадаад улс болон олон улсын байгууллагын зээл тусlamжид хамруулах, хувийн хөрөнгө оруулалтыг татах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санхүүжүүлэн хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Р.Мэргэн), Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс, Иргэний нисэхийн ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т тус тус даалгасугай.
3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, биелэлтийг хагас жил тутам тайлагнаж ажиллахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс, Иргэний нисэхийн ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Махбал), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Т.Гомбосүрэн)-т тус тус даалгасугай.



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны
Од... дугаарсарын 29-ны өдрийн 17:00 тоот
тушаалтын хавсралт

**“ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЭХИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТЕЛБЕР” - ИГХ ЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

118268063 5919487 СБТ9513

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалтуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
Зорилт 1. Ерөнхий зориулатын нисэхийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн орчныг бурдүүлэх						
1.1.	Иргэний хууль болон нисэхийн багц журамд нэмэгт, оруулж зориулатын нисэхийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох.	1.1.1. Иргэний нисэхийн тухай иргэний хуулийн шинэчилсэн найруулгад дараах зохицуулалтыг тусгах, үнд: - ерөнхий зориулатын нисэхийн үйл ажиллагаа, зөвшөөрөл талаар; - ерөнхий зориулатын нисэхийн үйл ажиллагаанд оролцгчдын эрх, үүрэг, хариуцлага; - ерөнхий зориулатын нисэхийн болон агаарын тээврийн хөгжлийг дэмжих нисэхийн хөгжлийн сан байгуулах.	Иргэний нисэхийн тухай зориулатын нисэхийн тухай иргэний хуулийн шинэчилсэн найруулгад дараах зохицуулалтыг тусгах, үнд: - ерөнхий зориулатын нисэхийн үйл ажиллагаа, зөвшөөрөл талаар; - ерөнхий зориулатын нисэхийн үйл ажиллагаанд оролцгчдын эрх, үүрэг, хариуцлага; - ерөнхий зориулатын нисэхийн болон агаарын тээврийн хөгжлийг дэмжих нисэхийн хөгжлийн сан байгуулах.	Иргэний нисэхийн тухай зориулатын нисэхийн тухай иргэний хуулийн шинэчилсэн найруулгад дараах зохицуулалтыг тусгах, үнд: - ерөнхий зориулатын нисэхийн үйл ажиллагаа, зөвшөөрөл талаар; - ерөнхий зориулатын нисэхийн үйл ажиллагаанд оролцгчдын эрх, үүрэг, хариуцлага; - ерөнхий зориулатын нисэхийн болон агаарын тээврийн хөгжлийг дэмжих нисэхийн хөгжлийн сан байгуулах.	ЗТХЯ ИНЕГ	МАТХ ЕЗАТХ
	1.1.2. Ерөнхий зориулатын нисэхийн үйл ажиллагааг зохицуулах иргэний нисэхийн багц дүрэмд зохицуулалт шаардлагатай дүрмийг боловсруулах.	Иргэний нисэхийн тухай зориулатын нисэхийн тухай иргэний нисэхийн багц дүрэмд зохицуулалт шаардлагатай дүрмийг боловсруулах.	Иргэний нисэхийн тухай зориулатын нисэхийн тухай иргэний нисэхийн багц дүрэмд зохицуулалт шаардлагатай дүрмийг боловсруулах.	ЗТХЯ ИНЕГ	МАТХ ЕЗАТХ	+

1.2.	Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхпэх зөвшөөрөл олгох, үнэмлэхжүүлэх, нислэгийн захиалга, төлөвлөлтийн хялбаршуулах, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний дүрэм, журмыг боловсронгуй болгох	1.2.1. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шаардлагыг тогтоох, хялбаршуулах /ЗГУАХХАХТ-2.115.(2)/	Зохицуулалтыг хялбаршуулах, боловсронгуй болгох	ЗТХЯ ИНЕГ	ЕЗАТХ	+
		1.2.2 Бага оврын агаарын хөлтийн нислэгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хялбаршуулах /ЗГУАХХАХТ-2.115.(2)/	Хяналтыг хялбаршуулах, боловсронгуй болгох	ИНЕГ	ЕЗАТХ	+
		1.2.3. Ерөнхий зориулалтын нислэгийн хөдөлгөөний мэдээлэл, зохицуулалтын нэгж байгуулж, нислэгийн захиалга, тепөвлөлтийг хялбаршуулах	Мэдээлэл, зохицуулалтын нэгж байгуулах	ИНЕГ	ЕЗАТХ	+
		1.2.4. “Хяналтгүй агаарын зайд нислэг Үйлдэх журам”-д шаардлагатай нэмэгт, өөрчлөлт оруулах, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний дүрэм, журмыг сайжруулах	Зохицуулалтыг боловсронгуй болгох	ИНЕГ	-	+
1.3.	Холбогдох төрийн байгууллага болон ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч, бусад оролцогчийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлага, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох судалгаа хийх	1.3.1. Нислэгийн үйл ажиллагааны төрлөөс хамаарч оролцогч талуудын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны хангальтн шаардлага, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох судалгаа хийх	Аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тодорхойлох	ИНЕГ	ЗТХЯ Холбогдох төрийн байгууллагууд	+
		1.3.2. Нислэгийн үйл ажиллагаанд оролцогчд талуудын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны хангальтн шаардлагыг тогтоох, үйл ажиллагааны шаардлагаанд, заасаг захиргaa, эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох	Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих	ИНЕГ	ЗТХЯ Холбогдох төрийн байгууллагууд	+
1.4.	Ерөнхий зориулалтын агаарын хөлөг ашиглах төрийн байгууллага болон	1.4.1. Орон нутгийн засаг захиргaa, хөдөө аж ахуй, онцой байдал, эрүүл мэнд, байгаль хамгаалах зэрэг	Хамтран ашиглах зохицуулалт	ЗТХЯ	Холбогдох төрийн байгууллагууд	+

	салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоот хангах	чиглэлээр хамтран ажиллах хүрээг тодорхойлох /ЗГУАХХАХТ-2.115.(2)/	бүрдэж, хэрэгжих				
	1.4.2. Аялал жуулчлалын чиглэлийг нисэх буудал, ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийн төлөвлөлтийн уялдуулан төлөвлөх /ЗГУАХХАХТ-2.115.(2)/	Хамтран ашиглах зохицуулалт бүрдэж хэрэгжих	3ТХЯ	Холбогдох төрийн байгууллагууд	+	+	+
	1.4.3. Эмнэлгийн яаралтай туслаамж үзүүлэх, онцгой байдлын үед ашиглах хөөрч буух зурvas, вертодром байгуулах байршилг хамтран тогтоож, хэрэгжүүлэх /ЗГУАХХАХТ-2.115.(2)/	10-аас доошгүй байршил тогтоох, байгуулах	3ТХЯ	Холбогдох төрийн байгууллагууд	+	+	+
1.5.	Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхпэхэд түрээс, хөнгөлөлттэй зээл зэрэг санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бурдуулэх	1.5.1. Агаарын хөлгийн буртгэлтэй уялдуулж ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхпэх түрээс, хөнгөлөлттэй зээл зэрэг санхүүгийн бүтээгдэхүүн бий болгох /ТИНСББХАХТ-4.1./	Агаарын хөлөг барьцаалан зээл авах тогтолцоо бүрдэж хэрэгжих	3ТХЯ ИНЕГ	ЕЗАТХ	+	+
		1.5.2. Ерөнхий зориулалтын агаарын хөлтийг сургалтын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс түрээсээр авч ашиглах зохицуулалт бурдуулэх	Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих	3ТХЯ ИНЕГ	ЕЗАТХ	+	+
1.6.	Иргэд хувийн хэрэцээндээ зориулан агаарын хөлөг, нисдэг тэрэг авч ашиглахад татварын дэмжлэг үзүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх	1.6.1.Дэлхийн худалдааны байгууллагын "Иргэний агаарын хөлтийн худалдааны хэлэлцээр"-т нэдэн орж, олон улсын зохицуулалт бурдуулэх /ТИНСББХАХТ-4.5./	Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих	3ТХЯ	Холбогдох төрийн байгууллагууд	+	+
		1.6.2. "Иргэний агаарын хөлтийн худалдааны хэлэлцээр"-т дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, зохицуулалтыг бурдуулэх /ТИНСББХАХТ-4.5./	Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих	3ТХЯ ИНЕГ			

1.7.	Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах газрын хэмжээ, байршлыг орон нутгийн засаг захиргаатай хамтран тогтоож, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгах /ЗГУАХХАХТ-5.2.4 (2)/ чөлөөлөх зохицуулалтыг судлан шийдвэрлүүлэх	<p>1.7.1. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах газрын хэмжээ, байршлыг орон нутгийн засаг захиргаатай хамтран тогтоож, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгах /ЗГУАХХАХТ-5.2.4 (2)/</p> <p>1.7.2. Ерөнхий зориулалтын нисэхэт ашиглах газрын суурь үнэлгээг тогтоох, газрын төлбөрийг бууруулах, чөлөөлөх талаар холбогдох хууль тогтоомжид тусгах /ЗГУАХХАХТ-5.2.4(2), ТИНСББХАХТ-8.2/</p> <p>1.7.3. Хөөрч буух зуравас, вертодром, шатахуун хангамж, ангар барих зэрэг газрын зориулалт, төлөвлөлтийг тодорхойлох, байршлыг тогтоох /ЗГУАХХАХТ-5.2.4.(2)/</p>	<p>Хөөрч, буух 116 зуравас, шатахуун хангамжийн 30 төв байгуулах байршиг тогтоох, баталгаажуулах</p> <p>Газрын төлбөрийн зохицуулалт бүрдэж хэрэгжих</p> <p>Газрын төлөвлөлт тодорхой болох</p>	<p>ЗТХЯ ИНЕГ</p> <p>ЗТХЯ ИНЕГ</p> <p>ЗТХЯ ИНЕГ</p>	<p>Холбогдох төрийн байгууллагууд Орон нутгийн засаг захиргаа</p> <p>Холбогдох төрийн байгууллагууд Орон нутгийн засаг захиргаа</p> <p>Холбогдох төрийн байгууллагууд Орон нутгийн засаг захиргаа</p>	<p>+</p> <p>+</p> <p>+</p>	<p>+</p> <p>+</p> <p>+</p>	<p>+</p> <p>+</p> <p>+</p>
1.8.	Ерөнхий зориулалтын агаарын хөлтөөр алслагдсан сум, суурин газарт агаарын тээврийн Уйлчилгээний тогтолцоог бий болгох	<p>1.8.1. Алслагдсан сум, суурин газарт агаарын тээврийн Уйлчилгээ Узүүлэх зайлшгүй хөтөлбөр, боловсруулан баттуулж, хэрэгжүүлэх /ЗГУАХХАХТ-2.114.(2)/</p> <p>1.8.2. Агаарын тээврийн зайлшгүй Уйлчилгээ Узүүлэхд тохиромжтой агаарын хөлгийн судалгаа хийж, техник, эдийн засгийн үр ашгийн боломжийг тодорхойлох</p>	<p>Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих</p> <p>Эрх зүйн зохицуулалт тодорхойлох</p>	<p>ЗТХЯ</p> <p>ИНЕГ</p>	<p>ИНЕГ, Хувийн хэвшлийн байгууллагууд</p> <p>Хувийн хэвшлийн байгууллагууд</p>	<p>+</p> <p>+</p>	<p>+</p> <p>+</p>	

Зорилт 2. Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн ур өгөөжийг нэмэгдүүлэх

2.1.	Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад	<p>2.1.1. Барилга байгууламжийн зохих хэсийг агаарын хөлгийн засвар үйлчилгээ, сургалтын чиглэлээр</p>	<p>Ерөнхий зориулалтын Чиглэлээр</p>	<p>ИНЕГ ЕЗАТХ</p>	<p>Хувийн хэвшлийн байгууллагууд</p>	<p>+</p> <p>+</p>	<p>+</p> <p>+</p>
------	--	--	--------------------------------------	-------------------	--------------------------------------	-------------------	-------------------

	оруулж, “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг нүүлгэн шилжүүлсний дараа одоогийн нисэх буудлын барилга байгууламжийн зохих хэсгийг өрөнхий зориулалтын нисэхийн төв болгон өөрчлөн зохион байгуулах	ашиглах нисэхийн байгуулах	өрөнхий төв байгуулах	зориулалтын зохион	нисэхийн төв байгуулах	
2.2.	Орон нутаг дахь ашиглагдахгүй болсон нисэх буудал, агаарын хөлөг хөөрч буух зурvas, талбайг сэргээн сайжруулж, өрөнхий зориулалтын нисэхэд ашиглах	2.2.1. Улсын төсвийн болон орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар тухайн орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, аялал жуулчлал, уул уурхай зэрэг салбарын хөгжилтэй уялдуулан нисэх буудал, хөөрч буух зурvas, талбайг сэргээн сайжруулах /ЗГҮАХХАХТ-4.4.2.(1)/	116 зурvas, талбай байгуулах, үйл ажиллагааг тогтвожуулах	ИНЕГ	Орон нутгийн засаг захиргаа, Холбогдох Төрийн байгууллагууд	
	2.2.2. Сэргээн сайжруулсан нисэх буудал, агаарын хөлөг хөөрч буух зурvas, талбайн засвар арчлалт, ашиглалтыг орон нутгийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх тогтолцоо бурддүүлэх	2.2.3. Орон нутгийн төсөөн, хувийн хөрөнгө оруулалтаар ангарын барилга байгууламж, шатахуун хангажийн төв барих, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломж бурддүүлэх./ЗГҮАХХАХТ-2.115.(3)/	Шатахуун хангажийн 30 төв байгуулах, үйл ажиллагааг тогтвожуулах			
2.3.	Барилга байгууламжийн дээвэр, хот суурин газрын талбайд вертодром байгуулах, ашиглах үйл ажиллагааны норм,	2.3.1. Вертодром байгуулах, ашиглах, үйл ажиллагааны стандарт, шаардлагыг тогтоох /ЗГҮАХХАХТ-2.115 (2), /ТИНСББХАХТ-8.2/	Стандарт, норм боловсруулах, баттуулах	ЗТХЯ ИНЕГ	МАТХ ЕЗАТХ	

	стандартыг баталж, хэрэгжүүлэх	2.3.2. Ерөнхий зориулалтын нисэхийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан батлуулах /ЗГУАХХАХТ-2.115 (2)/	Дэд хөтөлбөр боловсруулах хэрэгжүүлэх	ИНЕГ	3ТХЯ ЕЗАТХ	+	+	+
2.4.	Хот, суурин газар, сурьшлын бүсэд нийтийн хэрэгцээнд ашиглах вертодром байгуулах	2.4.1. Хот суурин газар, суурьшлын бүсэд, вертодромын байгуулах /ГИНСББХАХТ-8.2/	Стандарт, норм боловсруулах, батлуулах	3ТХЯ ИНЕГ	Хувийн хэвшлийн байгууллагууд	+	+	+
		2.4.2. Эмнэлэг болон томоохон зочид буудал, барилга, суурьшлын бүсэд вертодром байгуулах /ЗГУАХХАХТ-2.115 (2)/	Вертодром байгуулах, ашиглах	3ТХЯ ИНЕГ	Хувийн хэвшлийн байгууллагууд	+	+	+
2.5.	Ерөнхий зориулалтын агаарын хөлтийн хөөрч, буух зурсас, вертодром барж байгуулахад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, тер, хувийн хэвшлийн туншлэл болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих	2.5.1. Орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар хөөрч, буух зурсас, вертодром барьж байгуулахад дэмжлэг үзүүлж, тогтвортой үйл ажиллагааг явуулах боломж бурднуулэх. /ЗГУАХХАХТ-2.115 (2)/	Хувийн вертодром байгуулах, ашиглах боломж бурднуулэх	3ТХЯ ИНЕГ	Орон нутгийн захиргаа Хувийн хэвшлийн байгууллагууд	+	+	+
Зорилт 3. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын зайн зохицуулалт, аюултуй ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах								
3.1.	Ерөнхий зориулалтын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний үүрэг, хариуцлагыг боловсронгуй болгох	3.1.1. Иргэний нисэхийн багц дүрэм, холбогдох журамд тусган батлуулах.	Холбогдох зохицуулалтыг тусгах, хэрэгжүүлэх	ИНЕГ	ЕЗАТХ	+	+	+
3.2.	Ерөнхий нислэгийн ажиллагаанд агаарын зохицуулалтыг	3.2.1. Иргэний нисэхийн багц дүрэмд нийцүүлэн агаарын зайн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ашиглалтыг хялбаршуулах зайн /ЗГУАХХАХТ-2.115.(3)/	Доод агаарын зайн ашиглалтыг сайжруулах	ИНЕГ	ЕЗАТХ	+	+	+

	сайжруулах, ашиглалтыхялбаршуллах	3.2.2. Олон улсын болон орон нутгийн нисэх буудалд ерөнхий зориулалтын агаарын хөлгөөр шөнийн, хэрэглэлийн нислэгийн дурмээр нислэг Үйлдэх схем боловсруулах /ЗГУАХХАХТ-2.115.(2)/	Нислэг Үйлдэх схем баттуулах, хэрэгжүүлэх			
3.3.	Хяналтгүй агаарын зайн мэдээллийг хэрэглэгчид мэдээлэх тогтолцоог бий болгох, холбогдох баримт бичиг, гарын авлагаяар хангах	3.3.1. Ил харааны нислэгийн газрын зурагт газарзүйн байришил, агаарын зайн ангиллыг тэмдэглэж баттуулах. /ЗГУАХХАХТ-2.115.(2)/ 3.3.2. Агаарын зайн мэдээллийг хэрэглэгчид мэдээлэх, холбогдох баримт бичиг, гарын авлагаяар хангах тогтолцоог бий болгох /ЗГУАХХАХТ-2.115.(2)/	Хэрэглэгчийг тогтолцоо хангах Мэдээлээр хангах тогтолцоо бий болгох	ИНЕГ	ЕЗАТХ	+
Зорилт 4. Ерөнхий зориулалтын нисэхийн салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцоог бурдүүлэх						
4.1.	Хувийн нисэгч бэлтгэх анхан шатны сургалтын тогтолцоог бурдүүлж, улмаар ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцэд суурилсан, олон улсын стандарт шаардлага хангасан, бус нутгийн хэмжээнд сургалт зохион байгуулах Сургалтын төвийн байгуулж, уйл ажиллагааг тогтворжуулах	4.1.1. Хувийн нисэгч бэлтгэх анхан шатны сургалтын төвүүдийн байгуулах тогтолцоо бурдүүлэх, хэрэгжүүлэх 4.1.2. Олон улсын стандарт шаардлага хангасан, бус нутгийн хэмжээнд сургалт зохион байгуулах Сургалтын төвийн байгуулж, уйл ажиллагааг тогтворжуулах	Сургалтын төв, нисэх клуб 25-ыг байгуулж, уйл ажиллагааг тогтворжуулах	ИНЕГ	Хувийн хэвшлийн байгууллагууд ЕЗАТХ	+
4.2.	Ерөнхий зориулалтын агаарын хөлтийн нисэгч, инженер техникийн ажилтныг бэлтгэх зах зээлийн судалгаа хийх, хэрэгцээ шаардлагыг тогтоож, сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	4.2.1. Монгол Улсад нисэгч, инженер техникийн ажилтныг бэлтгэх зах зээлийн судалгаа хийх, хэрэгцээ шаардлагыг тогтоож, сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	Судалгаа хийх, 100-аас доошгүй нисэгч бэлтгэх	ИНЕГ	ЕЗАТХ	+

4.3.	Хувийн нисэх клуб, сургалтын байгууллагыг дэмжих	4.3.1. Иргэний нисэхийн багц дүрмийн хүрээнд нисэх клуб, сургалтын байгууллагаад эрх шилжүүлэх, гэрчилгээжүүлэх зохицуулалт бурдүүлэх	Зохицуулах тогтолцоог бурдүүлэх	ИНЕГ	ЕЗАТХ Хувийн хэвшлийн байгууллагууд	+	+	+
Зорилт 5. Бага оврын агаарын хөлгийн үйлдвэрлэл, засвар, Үйлчилгээний сүлжээг бий болгох								
5.1.	Олон Улсын иргэний нисэхийн давшилтэт техник, технологи нэвтрүүлэх, өөрийн орны нөхцөлд тохирсон бага оврын агаарын хөлөг угсрах, Үйлдвэрлэхдээд урт хугацаатай хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжилэг үзүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх	5.1.1. Бага оврын агаарын хөлөг угсрах, Үйлдвэрлэх чилэгээр гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалт хийж таатай орчинг бий болгох. 5.1.2. Бага оврын агаарын хөлөг түрээсээр болон худалдан авахад агаарын хөлгийг барьцаалан урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох дотоодын эрх зүйн зохицуулалтыг бурдүүлэх	Эрх зүйн зохицуулалт бурдэж хэрэгжих	ИНЕГ	ЕЗАТХ, Хувийн хэвшлийн байгууллагууд	+	+	+
5.2.	Бага оврын агаарын хөлөг угсрах, Үйлдвэрлэх, туршилт баталгаажуулалт хийх, засвар Үйлчилгээний төвүүд байгуулах	5.2.1. Бага оврын агаарын хөлгийг угсрах, Үйлдвэрлэх, туршилт баталгаажуулалт хийх ажлыг ИНБД-ийн хүрээнд дэмжих, гэрчилгээжүүлэх. /ЗГУАХХАХТ-2.114 (17)/	60-аас доошгүй засвар, Үйлчилгээний төв байгуулах, Үйл ажиллагааг тогтвортжуулах.	ИНЕГ	ЕЗАТХ, Хувийн хэвшлийн байгууллагууд	+	+	+
5.3.	Томоохон хот, суурин газар, орон нутагт өрөнхий зориулалтын агаарын хөлтийн засвар Үйлчилгээний төв байгуулахыг ИНБД-ийн хүрээнд дэмжих, гэрчилгээжүүлэх. /ЗГУАХХАХТ-2.114 (17)/	5.3.1. Ерөнхий зориулалтын агаарын хөлтийн засвар Үйлчилгээний төв байгуулахыг ИНБД-ийн хүрээнд дэмжих, гэрчилгээжүүлэх. Уйлчилгээний төв байгуулахыг дэмжих, суджээ бий болгох						
5.4.	Агаарын хөлтийн сэлбэг, тоног төхөөрөмжийн	5.4.1. Агаарын хөлтийн сэлбэг, тоног төхөөрөмжийн хангамж,	Эрх зүйн зохицуулалт бурдэж хэрэгжих	ИНЕГ	ЕЗАТХ,	+	+	+

	хангамж, Үйлчилгээний сүлжээ бий болгох	Үйлчилгээний сүлжээ бий болгох эрх зүйн зохицуулалт бурдүүлэх		Хувийн хэвшлийн байгууллагууд	
Зорилт 6. Ерөнхий зориулалтын агаарын хөлтийн шатахуун хангамжийн сүлжээг бий болгох					
6.1.	Ерөнхий зориулалтын агаарын авгас болон бусад төрлийн шатахууныг олон эх үүсвэрээс нийлүүлэх боломж бурдүүлэх	6.1.1. Ерөнхий зориулалтын агаарын хөлөгт хэрэглэгдэх шатахуунд тавигдах норм, стандартыг тогтоох	Норм, стандарт батлах, хэрэгжүүлэх	ИНЕГ	ЕЗАТХ, Хувийн хэвшлийн байгууллагууд + +
6.2.	Томоохон хот, суурин газар, орон нутгait өрөнхий зориулалтын агаарын хөлтийн шатахуун хангамжийн сүлжээ байгуулалтад, нийлүүлэх эх үүсвэр, хилийн боомтыг тогтоох судалгаа хийх /ЗГУАХХАХТ-2.17.3/	6.2.1. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээ байгууллах, нийлүүлэх эх үүсвэр, хилийн боомтыг тогтоох судалгаа хийх /ЗГУАХХАХТ-2.17.3/	Судалгаа хийх, хэрэгжүүлэх	ИНЕГ	ЕЗАТХ, Хувийн хэвшлийн байгууллагууд 15 35 35
	6.2.2. Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн агаарын хөлгийн шатахуун хангамжийн төв, агууллахын онцвчтой сүлжээг бий болгох /ЗГУАХХАХТ-2.17.3/	30-аас доошгүй байршилд шатахуун хангамжийн төв байгуулах	ИНЕГ	ЕЗАТХ, Хувийн хэвшлийн байгууллагууд + + +	
Зорилт 7. Иргэд хувийн хэрэгцээндээ агаарын хөлөг ашиглахыг дэмжин хөгжүүлэх					
7.1.	Иргэний хувийн хэрэгцээнд ашиглах агаарын хөлөг, нисдэг тэрэгт тавигдах стандарт, шаардлагыг тогтоох судалгаа хийх	Стандарт батлах, хэрэгжүүлэх			
	7.1.1. Хувийн хэрэгцээнд ашиглах бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэгт тавигдах стандарт, шаардлагыг тогтоох судалгаа хийх				
	7.1.2. Хувийн хэрэгцээнд бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэг ашиглах, эйр такси болон бусад бүтээгдэхүүн, үйлчилгээ гүйцэтгэх эрх зүйн зохицуулалт бурдүүлэх	Эрх зүйн зохицуулалт бурдэж хэрэгжих	ЗТХЯ ИНЕГ	ЕЗАТХ, Хувийн хэвшлийн байгууллагууд + + +	
	7.1.3. Агаарын хөлөг худалдан авах, түрээслэхэд урт хугацаатай хөнгөлөлттэй зээл болон бусад	Судалгаа хийх, хэрэгжүүлэх			

	терлийн санхүүгийн дэмжлэг узүүлэх талаар судалгаа хийх, шийдвэрлэх.	арга замыг тодорхойлох						
7.2.	Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх талаар агаарын хөтлийн холбоо, навигацийн төхөөрөмжийн шаардлагыг боломжит хамгийн бага төвшинд байгах зохицуулалтыг хийх	7.2.1. Холбогдох зохицуулалтыг "Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журам"-д тусгах, хэрэгжүүлэх 7.2.2. Агаарын хөлгийн тракинг систем, зөврийн ELT зэрэг төхөөрөмжийт өргөн ашиглах, импортоо, энэ чиглэлээр дотоодын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэх	Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих	ИНЕГ	МАТХ, ЕЗАТХ, Хувийн хэвшлийн байгууллагууд	+	+	+

Товчилсон үгийн тайлбар:

ЕЗАТХ-Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчдийн холбоо;
 ЗТХЯ -Зам, тээврийн хөгжлийн яам;
 ЗГУАХХАХТ-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
 /Засгийн газрын 2016 оны 121 дугаар тогтоолоор баталсан/
 ИНЕГ-Иргэний нисэхийн ерөнхий газар;
 МАТХ- Монголын агаарын тээвэрлэгчдийн холбоо
 ТИНСББХАХТ-Төрөөс иржээний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогыг хэрэгжүүлэх араг хэмжээний төлөвлөгөө
 /Засгийн газрын 2013 оны 428 дугаар тогтоолоор баталсан/

---00---